



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/145

Булган сум

“Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших” уриалга гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор үндэсний дээл, хувцсаа 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн Даваа гарагт өмсөж хэвшүүлэхийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус уриалсугай.

2. Энэхүү уриалга нь Төрийн тусгай албаны алба хаагчдад хамаарахгүй болохыг дурдсугай.

3. Дээрх уриалгыг аж ахуйн нэгж, албан байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (Г.Алдармөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

